



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/455

Мөрөн сум

Тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах
гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.1, 29¹ дүгээр зүйлийн 29¹.7, “Тусгай зориулалтаар 2023 онд агнах, барих агнуурын амьтны тоо толгойг тогтоох тухай” Монгол улсын Засгийн газрын 2022 оны 444 дүгээр тогтоол, “Амьтны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоол, “Босго үнийн хэмжээ тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 261 дүгээр тогтоол, “Хуваарь батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/182 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих зөвшөөрөл олгох хоёр дахь дуудлага худалдааны нэр бүхий ялагч нарын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагч нартай “тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих” гэрээ байгуулж, хамтран ажиллахыг аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал)-д даалгасугай.

3. Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих зөвшөөрлийн үнэ, төлбөр хураамжийг хуульд заасан хугацаанд, холбогдох дансанд төвлөрүүлж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

4. Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих зөвшөөрөл олгох дуудлага худалдааны үр дүнг олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан (Б.Сарантуяа)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/У/СХ дугаар захирамжийн хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНУУРЫН АМЬТНЫГ АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ДУУДЛАГА ХУДАЛДААНД ЯЛАГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Сумын нэр	Голын сав газрын нэр	Багц	Ялагч Байгууллага, иргэний нэр	Амьтны зүйлийн нэр	Тоо толгой (ширхэг)	Экологи эдийн засгийн үнэлгээ (төгрөгөөр)	Дэнчин үнэ (төгрөгөөр)	1 багцын босго үнэ (төгрөгөөр)	Дуудлага худалдаанд дуудсан ялагчийн дээд үнэ (төгрөгөөр)	Төлвөл зохих Мөнгөн дүн (төгрөгөөр)
1	Ренчинлхүмбэ	Шишхэд	1	Грийн гейт трейвэл ХХК	Тул загас	15	408000	122400	81600	181600	304000
2	Ренчинлхүмбэ	Шишхэд	3	Taimen lodge ХХК	Тул загас	5	408000	40800	81600	181600	222400
3	Ренчинлхүмбэ	Шишхэд	6	Taimen lodge ХХК	Тул загас	4	408000	32640	81600	181600	214240
4	Эрдэнэбулган	Эг	3	А.Баасандорж	Тул загас	2	408000	16320	81600	231600	247920
5	Цагаан-Үүр	Үүр	2	Т.Баяржаргал	Тул загас	3	408000	24480	81600	131600	156080
6	Рашаант	Сэлэнгэ	1	Майн ХХК	Тул загас	5	408000	40800	81600	131600	172400
НИЙТ ДҮН							2448000	277440	489600	1039600	1317040

_____ оооо